

# Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны нэгдсэн тайлан боловсруулах Хараат бус хянагч - нэгтгэгчийн ажлын даалгавар

## 1 Оршил

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) нь газрын тос, байгалийн хий болон уул уурхайн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжин ажилладаг дэлхий нийтийн стандарт юм.

ОУИТБС-ын хэрэгжилт нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- Ил тод байдал: газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын компаниуд нь Засгийн газарт төлсөн төлбөрөө, Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо ил болгоно. Эдгээр тоон баримтыг Хараат бус хянагч-нэгтгэгч нэгтгэж, нэгтгэсэн дүнг ОУИТБС-ын жилийн тайланд олборлох салбарын нөхцөл байдал болон бусад мэдээллийн хамт хэвлэн нийтэлнэ.
- Хариуцлага: Засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэх олон талт ажлын хэсэг ОУИТБС-ын тайланг боловсруулах явцад хяналт тавих, үр дүнг нийтэд түгээх, тухайн улс дахь ил тод байдлыг нэмэгдүүлэх нийтлэг чармайлттай уялдуулахад дэмжлэг үзүүлэх эрх үүрэгтэй оролцоно.

ОУИТБС-ын тайлагналын бүрэн бүтэн байдал, иргэдийн дунд салбарын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, олон нийт, засгийн газар болон хувийн хэвшлийн ил тод, хариуцлагатай байх өндөр стандартыг хөхүүлэн дэмжихэд чиглэгдсэн ОУИТБС-ын хэрэгжилтийг өргөжүүлэх шинэлэг арга барилыг олон талт ажлын хэсэг (цаашид ОТАХ хэмээх) баримтлахыг ОУИТБС-ын стандарт дэмждэг. Хэрэгжүүлэгч орнуудад тавигдах шаардлагуудыг ОУИТБС-ын стандартад тусгасан болно<sup>1</sup>. Нэмэлт мэдээллийг [www.eiti.org](http://www.eiti.org)-с авна уу.

**ОТАХ нь ажлын төлөвлөгөөнд тусгасан ОУИТБС-ын зөвшилцсөн хамрах хүрээ, зорилтуудад суурилан Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын даалгаврыг батлах (шаардлага 4.9.b.iii) шаардлагатай.** ОТАХ нь эдгээр асуудлуудыг өөрийн дотоод засаглалын дүрэм, горимын дагуу хэлэлцэж, шийдвэрлэх юм (шаардлага 1.4.b-г харна уу). ОУИТБС нь оролцогч тал бүрийн тэгш түншлэлийн оролцоог хангасан шийдвэр гаргалтыг хэрэгжилтийн бүхий л үед баримтлахыг шаарддаг.

**Хараат бус хянагч-нэгтгэгч нь сайн, итгэл даахуйц, мэргэжлийн хувьд чадвартай гэсэн дүгнэлт олон талт ажлын хэсгээс авч чадсан байх шаардлагатай (шаардлага 4.9.b.iii).** Олон талт ажлын хэсэг болон Хараат бус хянагч-нэгтгэгч нь ашиг сонирхлын зөрчилтэй холбогдолтой аливаа асуудлыг авч үзэх нь зүйтэй. Хараат бус хянагч-нэгтгэгчийн бэлтгэсэн тайланг Үндэсний зөвлөл болон ОТАХ-ээр батлуулахаар өгч, улмаар шаардлага 7.1-д заасны дагуу нийтэд ил болгоно.

Энэ ажлын даалгаварт ОУИТБС-ын шаардлага 4.9.b.iii-т заасан ОУИТБС-ын тайлагналын (хэсэг 4-ийг харна уу) “батлагдсан процедур”-ыг тусгасан байна. Олон улсын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын тайлагналыг илүү жигд, найдвартай болгох үүднээс эдгээр процедурыг боловсруулсан юм. ОУИТБС-ын процессыг одоо байгаа тайлагнал болон аудитын тогтолцоонд нэмэх, үнэлэх болон сайжруулах зорилгоор ашиглаж болох юм. Олон улсын Удирдах зөвлөл нь энэхүү процессыг аль болох одоо байгаа процедур, институциудад тулгуурлан явуулах, өөрөөр хэлбэл одоо байгаа дата цуглуулах, аудит хийх тогтолцоотой уялдуулах, сайтар үнэлэх, сайжруулахад ОУИТБС-ын процессыг чиглүүлэхийг зөвлөдөг. Ингэснээр ОУИТБС-ын процессыг

---

<sup>1</sup> <http://eiti.org/document/standard>

ашиглан бусад хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн чухал зөвлөмжүүдийг гаргах боломжтой юм.

### Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа нь

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-д нэгдэх шийдвэрээ 2006 онд анх гарган, хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газар ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийг Засгийн газар, уул уурхайн компани, иргэний нийгмийн төлөөллөөс байгуулж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна. Монгол Улсын ОУИТБС-ын 2006-2009 оны нэгдсэн тайлан гаргах зардлыг олон талт хандивлагчдын Итгэлийн сангаас санхүүжүүлж байсан бол Монгол Улсын Засгийн газар 2010 оны аудитын тайлан нэгтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж эхэлсэн бөгөөд одоо жил бүр улсын төсвөөс гаргаж байна.

Олон талт оролцогчдын ажлын хэсэг нь цомхон ажлын албаны туслалцаатайгаар ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулан Үндэсний зөвлөлөөр батлуулж, уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл явуулж байгаа болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компаниудаас бүх шатны (улс, аймаг, дүүрэг, сум) төсөвт төлсөн төлбөр, Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогын тайланг ижил маягтаар хоёр талаас гаргуулж байна. Тайлангийн маягтуудыг анх 2007 онд гаргаж, 2008, 2011, 2012, 2015 оны сүүлчээр шинэчлэн баталж, 2014 оноос эхлэн цахимаар тайлагнаж байна.

Энэ хугацаанд Монгол Улс нийт 13 тайлан гарган хэвлэн нийтлүүлсэн байна. Анх Монгол Улсын 2006 оны нэгдсэн тайланг Австралийн Крейн Уайт энд Ассоушиэтс хэмээх аудиторын компаниар, 2007 оны тайланг Монгол, Малайзын Эрнст Янг аудитын компаниудын консорциум, бол 2008, 2009, 2010, 2011, 2013, 2015, 2017 оны тайланг Их Британийн Харт Нойрс лдт, Монгол Улсын Улаанбаатар аудит корпорацийн консорциум гаргаж, харин 2012 оны тайланг Их Британийн Мүүр Стефенс, Монгол Улсын Далайван аудит компаниудын консорциум, 2014, 2016 он тайланг Кей Пи Эм Жи Монгол, Кей Пи Эм Жи Франц компаниудын консорциум гаргасан байна.

Хамгийн сүүлд 2018 оны нэгтгэл тайланг Монгол-Тунисийн БДО аудитын компаниудын консорциум боловсруулан гаргаад байна. Манай улсад ОУИТБС-ын тайлан гаргах үйл ажиллагаа жилээс жилд өсөн нэмэгдэж, нэгтгэл тайлангаар гарах зөрүү тогтвортой буурч байна. Тайланд хамрагдсан байдлыг харуулбал:

Он	Тайлан гаргасан компани	СЯ-ны тайланд орсон компаниуд	Улсын нэгтгэл тайланд орсон компаниуд	Нэгтгэгдсэн дүн төгрөг	Улсын төсвийн урсгал орлогод эзлэх хувь	Тайлбарлагдаагүй зөрүү, төгрөг
2006	64	137	25	492 тэрбум	36 хувь	4 тэрбум
2007	102	184	38	745 тэрбум	40 хувь	775 сая
2008	115	184	46	686 тэрбум	32 хувь	420 сая
2009	129	363	101	737 тэрбум	37 хувь	58 сая
2010	274	477	150	1275 тэрбум	48 хувь	356 мянга
2011	301	518	200	2150 тэрбум	54 хувь	75 сая
2012	1531	1829	200	1594 тэрбум	33 хувь	360 сая
2013	1197	1617	250	1576 тэрбум	27 хувь	37 сая

2014	992	1570	236	1579 тэрбум	25 хувь	581 сая
2015	747	1920	202	1393 тэрбум	30 хувь	112 сая
2016	1227	2086	213	1073 тэрбум	19 хувь	74 сая
2017	1489	2091	230	2358 тэрбум	28 хувь	236 сая
2018	1490	1986	202	2816 тэрбум	30,5 хувь <sup>2</sup>	279 сая

Монгол улсын энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнд баталгаажуулалт хийсэн дүнг ОУИТБС-ын олон улсын удирдах хороо хэлэлцэн, 2010 оны 10 дугаар сард Монгол улсыг ОУИТБС-ын “стандартыг хангасан 4 дэх орон”-оор ОУИТБС-ын хүлээн зөвшөөрч, 2011 онд тайлангаа тогтмол сайжруулж байгаагийн учир, 2016 онд цахим тайлагналыг нэвтрүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулсны төлөө ОУИТБС-ын олон улсын удирдах хорооны даргын нэрэмжит шагналаар манай улсыг шагнасан байна.

2016-2017 онд хийсэн баталгаажуулалтын үр дүнг ОУИТБС-ын удирдах хороо 2018 оны 2-р сард авч үзээд Монгол улсыг шаардлагыг хангасан дэлхийн 2 дахь орноор хүлээн зөвшөөрсөн байна.

## 2 Даалгаврын зорилго

Монгол Улсын Засгийн газар, ОУИТБС-ын ОТАХ-ийн нэрийн өмнөөс ажлын алба нь ОУИТБС-ын стандартын дагуу Хараат бус хянагч-нэгтгэгчийн үйлчилгээ үзүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, чадвартай бөгөөд итгэл даахуйц компанийг хайж буй болно. Даалгаврын зорилго нь ОУИТБС-ын стандартын дагуу ил тод байдлыг хангах явдлыг сайжруулах, ил болсон мэдээллийн иж бүрэн хамралт, үнэн бодит байдалд үнэлгээ өгөх, Засгийн газрын мэдээллийн систем, байгалийн баялгийн засаглалын удирдлагыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг тохиролцон хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хараат бус хянагч-нэгтгэгчээс хүлээгдэж буй ажлууд:

- ОТАХ-ийн шийдвэр гаргах үйл явцад зориулж Монгол Улсын 2019 оны нэгтгэл тайлангийн цар хүрээг тодорхойлох судалгаа хийх;
- ОУИТБС-ын стандарт болон энэ ажлын даалгаврын 3-т заасны дагуу Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэл тайланг боловсруулах;
- Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын хувьд салбарын засаглалыг сайжруулах, олон улсын жишигт хүрэхүйц хэмжээнд салбарыг удирдахад анхаарах бүтээлч дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах;


## 3 Үйлчилгээ, даалгавар болон хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажил нь таван үе шатнаас бүрдэнэ (зураг 1-ийг харна уу). Эдгээр үе шатууд нь зарим тохиолдолд давхардах эсхүл үе шат хооронд давтагдаж болно. ОУИТБС-ын тайлагнах үе шат ерөнхийдөө цар хүрээг тодорхойлох үе шатаар эхэлж болох ба зарим үед үүнийг Хараат бус хянагч-нэгтгэгч (Үе шат 0) эсхүл ОТАХ болон бусад зөвлөхүүд хийж гүйцэтгэдэг.

<sup>2</sup> 2018 оны улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,234.9 тэрбум төгрөг байв.

Хараат бус хянагч-нэгтгэгчийн үе шат бүхэнд хүлээх үүргийг дор дэлгэрэнгүй тусгасан болно.

Зураг 1 – ОУИТБС-ын тайлагналын процесс болон гарах бүтээгдэхүүнүүдийн тойм



### Үе шат 0 – Цар хүрээг тодорхойлох судалгаа

Зорилго:

Энэхүү үе шатны зорилго нь ОУИТБС-ын стандартад заасан шаардлагыг хангахын тулд 2019 оны тайланд юу хамруулахыг судалж, тодорхойлоход оршино. ОУИТБС-ын нэгдсэн тайлан нь 2 урсгалтай ашиглагддаг ба а) шийдвэр гаргагчдад бодлого боловсруулахад б) ард иргэдэд эрдэс баялгийн салбарын баталгаажсан мэдээллийг хүргэхэд чиглэсэн байдлаар боловсрогдсон байх үндсэн зорилготой. Цар хүрээг тодорхойлсноор цаг хугацаандаа, бүрэн бүтэн, найдвартай ОУИТБС-ын нэгтгэл тайлан гарах үндэс суурийг бий болгодог ба дараах зүйлсийг авч үзнэ.

Үүнд: тайлангийн хамрах санхүүгийн жилийн хугацаа, хамрах суурь мэдээллийн хүрээ, тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд, газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбараас олсон орлогуудаас аль нь материаллаг буюу чухал болох, аль компани, төрийн байгууллага заавал тайлагнах ёстой гэх зэрэг. Мөн энэ үе шат нь ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтыг биелүүлэхийн тулд хамгийн доод шаардлагыг давуулан биелүүлэх буюу ОУИТБС-ын тайлангийн цар хүрээг нэмэгдүүлэх эсэхийг үндэслэлтэйгээр шийдвэрлэхэд олон талт ажлын хэсэгт боломж олгодог. ОУИТБС-ын нэгтгэл тайланд оруулах шаардлагатай тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, хувилбар санал болгох, тайлагнах тохиромжтой арга зүйг зөвлөмж болгох зэрэг олон асуудлуудад ОТАХ-ийн анхаарлыг хандуулах боломж олгодог.

Хараат бус-хянагч нэгтгэгч нь цар хүрээг тодорхойлох үе шатанд дараах ажлуудыг хийнэ:

- Шаардлага 4-т заасан ОУИТБС-ын тайланд орох төлбөр, орлогын бүрэн бүтэн байдлыг нягтлах
- Шаардлага 4.1-т заасны дагуу ОУИТБС-ын тайлан гаргах төрийн байгууллага, компаниудын бүрэн бүтэн байдлыг нягтлах
- ОУИТБС-ын тайлан гаргаж буй төрийн байгууллага, компаниудын тайланг баталгаажуулахад ОТАХ-т дэмжлэг үзүүлэх. Үүнд холбогдох хууль, тогтоомж, ямар нэгэн шинэчлэлт хийхээр төлөвлөсөн эсхүл хийж буй эсэхийг нягтлах, тэдгээр үйл явц нь олон улсын стандарттай нийцэж буй эсэхийг нягтлах зэргийг ойлгоно.
- Хараат бус хянагч нэгтгэгч нь Сангийн яам, Үндэсний Статистикийн хорооны баталсан тайлангийн маягт, орлогын урсгалыг ашиглах бөгөөд 2019 оны тайланд шаардлагатай нэмэлт мэдээллийн маягт боловсруулан ОТАХ-т хүргүүлнэ. Маягтад зөвшилцсөн материаллаг босгоноос дээш давсан “бүх төрлийн материаллаг төлбөр, орлогыг” хамруулна.
- Төслийн түвшинд тайлагнах зорилгын хүрээнд:
  - “Төсөл” гэдэгт юуг авч үзэхийг дотоодын хууль журам, ашиглаж буй систем болон олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн тодорхойлох

- Төслийн түвшинд тайлагнах шаардлагатай орлогын урсгалуудыг тодорхойлж, тусгай зөвшөөрөл/гэрээний хувьд татвар ногдуулж тайлагнах мөн компанийн хувьд ногдуулж, тайлагнах орлогын урсгалуудыг ангилна.
- Холбогдох маягтуудын төслийг ОУИТБС-аас гаргасан төслийн түвшний тайлагналын загвар маягтын дагуу боловсруулна

Төслийн түвшинд тайлагнах талаар ОУИТБС-аас гаргасан зааварчилга, загвар маягтуудыг ашиглана.<sup>3</sup>

## **Үе шат 1 – Урьдчилсан дүн шинжилгээ ба эхлэлийн тайлан**

Зорилго: Эхлэлийн шатны зорилго нь ОУИТБС-ын тайлагнах үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхой тогтоох, үүнд тайлагналын маягтууд, өгөгдөл мэдээлэл цуглуулах журам, тайланг гаргах хугацаанууд орсон байна.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь хамрах хүрээг тодорхойлоход оролцсон бол эхлэлийн шат сунжрах ёсгүй. Хараат бус хянагч-нэгтгэгч хамрах хүрээг тодорхойлоход оролцоогүй бол дор дурдсан 1,1-1,2- т заасны хамрах хүрээг эргэн хянах зарим ажлыг хэрэгжүүлнэ. Эхлэлийн тайлан нь ОТАХ, Хараат бус хянагч-нэгтгэгч нарын хооронд ОУИТБС-ын тайлангийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх ажлуудын талаар харилцан ойлголцол байгааг нотолно.

ОУИТБС-ын тайлагналыг ОУИТБС-ын стандарт болон ОУИТБС-ын ажиллагааны талаарх ОТАХ-ээс баталсан зорилтууд болон хүлээлттэй нийцүүлж тодорхойлох нь чухал юм. Эхний үе шатны үр дүнг эхлэлийн тайланд тусгана (1.1-ийг харна уу). Хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах даалгавруудыг гүйцэтгэнэ:

- 1.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь олборлох салбарын засаглалын тогтолцоо, татварын бодлого, өмнө нь хийгдсэн хамрах хүрээ тогтоох ажлын үр дүн, өмнөх ОУИТБС-ын тайлангууд болон баталгаажуулалтаар өгөгдсөн зөвлөмж гэх мэт **холбогдох ерөнхий мэдээллийг нягтлан хянана**. (Холбогдох баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралтад тусгасан болно).
- 1.2 Цар хүрээг тодорхойлох судалгаа, 1.1-д заасны дагуу Эхлэлийн тайланд дараах мэдээллийг тусгасан байна:
  - 1.2.1 **ОУИТБС-ын тайланд хамрагдах төлбөр, орлогын материаллаг байдлыг шийдвэрлэсэн ОТАХ-ийн шийдвэр. Үүнд:**
    - Материаллаг байдал болон босгын тодорхойлолт, мөн үүнээс үүдэн шаардлага 4.1(с)-ийн дагуу хамрагдах орлогын урсгалууд.
    - Шаардлага 4.2-ийн дагуу үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого.
    - Шаардлага 4.3-ийн дагуу дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны хамрал.
    - Шаардлага 4.4-ийн дагуу тээврийн орлогын хамрал
    - Шаардлага 4.5-ийн дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хийсэн эсвэл хүлээн

<sup>3</sup> [https://eiti.org/sites/default/files/documents/reporting\\_template\\_for\\_project-level\\_reporting\\_option\\_1.xlsx](https://eiti.org/sites/default/files/documents/reporting_template_for_project-level_reporting_option_1.xlsx)

[https://eiti.org/sites/default/files/documents/reporting\\_template\\_for\\_project-level\\_reporting\\_option\\_2.xlsx](https://eiti.org/sites/default/files/documents/reporting_template_for_project-level_reporting_option_2.xlsx)

<sup>3</sup> [https://eiti.org/sites/default/files/documents/guidance\\_note\\_28\\_on\\_project-level\\_reporting\\_final.pdf](https://eiti.org/sites/default/files/documents/guidance_note_28_on_project-level_reporting_final.pdf)

авсан төлбөрийн нэгтгэл, тайлагнал

- Шаардлага 4.6-ийн дагуу материаллаг байдал болон орон нутагт хийгдэж буй шууд төлбөр
- Шаардлага 5.2-ийн дагуу материаллаг байдал болон орон нутаг дахь шилжүүлэг
- Шаардлага 4.7-ийн дагуу ОУИТБС-ын тайлангийн орлогын задаргааны түвшин ба төрлүүд.
- Шаардлага 6.1-ийн дагуу нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын хамрал.
- ОТАХ-ийн зөвшилцсөн бусад мэдээллүүд

### 1.2.2 ОУИТБС-ын тайлан гаргах төрийн байгууллага, компаниудыг тодорхойлсон ОТАХ-ийн шийдвэр. Үүнд:

- Шаардлага 4.1(с)-ийн дагуу улсад материаллаг төлбөр төлсөн, тайлагнах үүрэгтэй компаниуд болон төрийн өмчит компаниуд
- Шаардлага 4.1(с-d), 4.5 болон 4.6-ийн дагуу материаллаг төлбөр хүлээн авдаг, тайлагнах үүрэгтэй төвийн болон орон нутгийн төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд
- Материаллаг байдлын босгонд хүрэхгүй байгаа орлого гэх мэт төлбөрийн урсгал бүрээр хүлээн авсан орлогын нийт дүнг нэг бүрээр нь ОУИТБС-ын хамрах хүрээний дагуу бүрэн тайлагнахад засгийн газарт тулгарч буй бэрхшээллүүдийг олж тогтоох (шаардлага 4.1(d)).

1.2.3 “Төсөл” гэдэгт юуг авч үзэх тухай тодорхойлолт, төслийн түвшинд тайлагнах орлогын урсгалуудын тойм болон санхүүгийн мэдээллийг төслийн түвшинд хүртэл задалж тайлагнах тухай ОТАХ-ын шийдвэр.

1.2.4 Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлагнах үйл явцад оролцож буй компаниуд, төрийн байгууллагын аудит, баталгаажуулалтын үйл явцыг судалж үзсэний үндсэн дээр **шаардлага 4.9-д заасны дагуу өгөгдөл мэдээллийн чанарыг баталгаажуулах үүднээс хамрагдаж буй компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ямар мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид гаргаж өгөхийг** зааж өгнө.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын тайланг цогц, найдвартай гаргах үндэс бүрдүүлэхдээ өөрийн гэсэн дүгнэлт хийж, олон улсын мэргэжлийн стандартуудыг хэрэглэнэ<sup>4</sup>. Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд ашиглагдаж буй хяналт, аудитын хүрээг хэр хэмжээнд найдвартай гэж шийдвэрлэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргана. Хараат бус хянагч-нэгтгэгч нь ямар боломжуудыг авч судалсан мөн тухайн баталгаажуулалттай холбоотой үндэслэлээ баримтжуулна. Хэрэв Хараат бус хянагч-нэгтгэгч болон олон талт ажлын хэсгээс шаардлагатай гэж үзвэл дараах баталгаажуулалтыг хийнэ:

- Бөглөсөн тайлагналын маягт нь бүрэн бүтэн, үнэн зөв гэдгийг гэрчилсэн баримт бичигт тухайн компанийн эсвэл төрийн албаны удирдах ажилтан гарын үсэг зурахыг хүсэмжлэх.
- Хүргүүлсэн мэдээлэл нь бүрэн бүтэн, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлантай нийцэж буйг баталгаажуулсан захиаг тухайн компанийн хөндлөнгийн аудитороос хүсэмжлэх. Ийм захидал явуулахыг тухайн компанийн аудиторын ердийн ажлын нэг

---

<sup>4</sup> Жишээлбэл, ISA 505 нь хөндлөнгийн баталгаажуулалт, ISA 530 нь аудитын загварчилгаа; ISA 500 нь аудитын нотолгоо; ISRS 44000 харилцан тохиролцсон санхүүгийн мэдээлэл бүхий горимын ажлын гүйцэтгэл; 4410 нь нийцлийн ажлын гүйцэтгэл.

хэсэг болгох үүднээс ОТАХ нь ийм процедурыг нэвтрүүлж болох юм. Хэрэв зарим компаниуд хуулиар хөндлөнгийн аудитортой байх үүрэг хүлээгээгүй, тиймээс ч ийм баталгаажуулалт хийж өгөх боломжгүй тул энэ асуудлыг нарийн олж тогтоон, төлөвлөсөн эсвэл хэрэгжиж буй шинэчлэлийн хүрээнд авч үзэх нь зүйтэй юм.

- Хэрэв ач холбогдолтой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл хамрагдаж буй төрийн байгууллагуудаас хөндлөнгийн аудитор эсвэл түүнтэй дүйцэхүйц этгээдээс уг тайлагнасан мэдээлэл нь үнэн зөв гэдгийг гэрчлэх баримт бичиг шаардах нь зүйтэй.

Эхлэлтийн тайланд авч үзсэн хувилбарууд, баталгаажуулахад тулгарч буй бэрхшээлүүдийг баримтжуулсан байна.

- 1.3.4 ОУИТБС-ын тайланд орох орлогын бус мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг баталгаажуулах. Эхлэлтийн тайланд хүснэгт 1-ийг бэлтгэн хавсаргах ба эдгээр мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгч, ОТАХ, эсхүл бусад этгээдийн хэн нь ямар мэдээллийг гаргаж өгөхийг баталгаажуулж өгнө.

Хүснэгт 1 – ОУИТБС-ын тайланд орох “суурь мэдээлэл”

<b>ОУИТБС-ын тайланд орох суурь мэдээллүүд</b>	<b>Хараат бус хянагч-нэгтгэгчийн хийх ажлууд</b>
Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт, төсвийн бодлогын талаарх тодорхой мэдээлэл (шаардлага 2.1)	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яамнаас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;
Олборлох салбарын талаарх товч танилцуулга, үүнд хайгуулын томоохон үйл ажиллагааны талаарх мэдээлэл орно (шаардлага 3.1)	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;
Олборлох үйлдвэрлэлийн эдийн засагт оруулсан хувь нэмрийн талаарх боломжтой мэдээллүүд (шаардлага 6.3) Нэгтгэл тайлан гаргахдаа төсөл бүрээр тайлагнасан талуудын мэдээллийг ашигт малтмалын төрлөөр, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбараар төлбөр орлогыг гаргаж дүгнэлт тайлан гаргах	Сангийн яам, Үндэсний статистикийн хорооноос холбогдох мэдээллийг хүлээн авч нэгтгэх;
Үйлдвэрлэл, экспортын мэдээлэл (шаардлага 3.2 болон 3.3)	Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо болон аж ахуйн нэгжүүдээс холбогдох мэдээллийг хүлээн авч нэгтгэх;
Олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх мэдээлэл (шаардлага 2.6 болон 6.2) <sup>5</sup>	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс холбогдох мэдээллийг хүлээн авч нэгтгэх;
Олборлох салбараас олсон орлогын хуваарилалт (шаардлага 5.1);	Сангийн яамнаас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;

<sup>5</sup> Зааварчилгаа 18: ОУИТБС-ын тайлагнал дахь төрийн өмчит компанийн оролцоо, [https://eiti.org/files/GN/Guidance\\_note\\_18\\_SOEs\\_EN.pdf](https://eiti.org/files/GN/Guidance_note_18_SOEs_EN.pdf)

ОТАХ-ээс орлогын менежмент, зарцуулалтын талаар хүсэлт тавьсан нэмэлт мэдээлэл (шаардлага 5.3)	Сангийн яамнаас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;
Лиценз олгох явц, бүртгэл (шаардлага 2.3) <sup>6</sup> мөн лиценз олголтын талаарх мэдээлэл (шаардлага 2.2) <sup>7</sup> мөн лицензийн шилжилт хөдөлгөөн, тогтоосон журмаас гадуур олгогдсон тохиолдол	Ашигт малтмал, газрын тосны газраас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;
Эцсийн эзэмшигчийн талаарх ОТАХ-ээс хүсэмжилсэн аливаа мэдээлэл (шаардлага 2.5) <sup>8</sup>	Компаниудаас авч нэгтгэх;
Гэрээний талаарх ОТАХ-ээс хүсэмжилсэн аливаа мэдээлэл (шаардлага 2.4) <sup>9</sup>	Гэрээ байгуулсан орон нутгийн засаг захиргаа, компаниудаас авч нэгтгэх;
Олборлох үйл ажиллагааны улмаас учирсан байгаль орчны нөлөөллийн талаарх ОТАХ-ээс хүсэмжилсэн аливаа мэдээлэл (шаардлага 6.4) <sup>10</sup>	Байгаль, орчин аялал жуулчлалын яамнаас холбогдох мэдээллийг авч нэгтгэх;
Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлангаар өгөгдсөн зөвлөмжүүдийн биелэлтийг оруулах <sup>11</sup>	ОУЗСТ-ийн Ажлын албанаас авч нэгтгэх;
Олборлох салбарын орлогоор байгуулагдсан бүх төрлийн сангуудын мэдээлэл:	Төрийн байгууллага, УБЕГ, санхүүжүүлсэн компаниас авч нэгтгэх;

1.2.6 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **нууцлалын зэрэгт хамаарагдах мэдээллийг хамгаалахтай холбогдолтой зохих заалтуудыг зөвшилцөх** талаар ОТАХ-т зөвлөгөө өгнө. Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлагнагч байгууллагуудад зориулж тайлангийн маягыг хэрхэн бөглөх зааварчилгаа өгч, ОТАХ, ажлын албатай хамтран сургалт зохион байгуулна. Нэгтгэл тайлан боловсруулах явцад талуудтай уулзалт, хурал, сургалтыг хэдэн удаа хийх талаар төлөвлөгөөндөө тусгасан байна.

## **Үе шат 2 – Өгөгдөл мэдээлэл цуглуулах**

**Зорилго:** Энэ үе шатны зорилго нь эхлэлтийн тайланд заасан цар хүрээний дагуу ОУИТБС-ын тайлангийн мэдээллийг цуглуулахад оршино. ОТАХ, ажлын албанаас байгууллагуудын холбоо барих дэлгэрэнгүй хаягийг өгөх ба бүх байгууллагууд мэдээллээ гаргаж өгөхөд нь дэмжлэг үзүүлнэ.

Мэдээлэл цуглуулахад Хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах ажлуудыг хийнэ.

- 2.1 ОУИТБС-ын ажлын албанд тайлангийн маягыг хүргүүлж ОТАХ-ээс Хараат бус хянагч-нэгтгэгчид өгсөн үүрэг даалгавар буюу 1.3.4-т заасан бүх мэдээллийг холбогдох баримтын хамтаар Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системээр цуглуулна.
- 2.2 Өгсөн мэдээлэл зөрүүтэй тохиолдолд тайлагнагч байгууллагууд руу шууд холбогдож тодруулах

<sup>6</sup> Зааварчилгаа 3: Лицензийн бүртгэл, <https://eiti.org/files/GN/Guidance-note-3-License-Registers.pdf>

<sup>7</sup> Зааварчилгаа 4: Лиценз олголт, [https://eiti.org/files/Guidance%20note%204%20-%20License%20Allocations\\_FINAL\\_20131113.pdf](https://eiti.org/files/Guidance%20note%204%20-%20License%20Allocations_FINAL_20131113.pdf)

<sup>8</sup> Эцсийн эзэмшигчийн загвар мэдүүлгийн хуудас, <https://eiti.org/files/Template-beneficial-ownership-declaration-form.doc>

<sup>9</sup> Зааварчилгаа 7: Гэрээний ил тод байдал, <https://eiti.org/files/Guidance-note-7-Contract-transparency.pdf>

<sup>10</sup> Зааварчилгаа 7: Гэрээний ил тод байдал, <https://eiti.org/files/Guidance-note-7-Contract-transparency.pdf>

<sup>11</sup> 2016 оны Нэгтгэл тайлангийн зөвлөмжүүдийг 2018 оны 1 дүгээр сарын 15—наар тодорхой болгосон байна.



### **Үе шат 3 – Анхан шатны нэгтгэл**

**Зорилго:** Энэ үе шатанд салбарын суурь мэдээлэл болон төлбөрийн мэдээлэлд анхан шатны тулган баталгаажуулалт, нэгтгэл хийж, ямар нэгэн зөрүү гарсан тохиолдолд түүнийг судлан тогтооход оршино.

- 3.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлан гаргасан байгууллагуудын төлсөн төлбөр, орлогыг нэгтгэж, өгөгдлийн сан үүсгэнэ.
- 3.2 Хараат бус хянагч-нэгтгэгч нь хамрах хүрээний дагуу хамрагдаж буй аж ахуй нэгжүүдийг тайлагнасан мэдээллийг нэгтгэж, аливаа зөрүү (үүнд буцаан олгогдсон зөрүү орно)-г олж тогтооно.
- 3.3 Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОТАХ-тай ямар хэмжээний зөрүүнээс дээш зөрүүг олж тогтоох талаар зөвшилцөн тохирч, зөрүүг олж тогтооно

### **Үе шат 4 – Зөрүүг шалгаж, ОУИТБС-ын тайлангийн төслийг бэлтгэх**

**Зорилго:** Энэ үе шатанд анхан шатны суурь болон орлогын мэдээллийг тулгах ажлыг эцэслэж, зөрүүг судлан тогтооход оршино.

- 4.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлагнасан датанд гарсан аливаа зөрүүг тодруулахаар тайлагнасан аж ахуйн нэгжтэй шууд холбогдож, нэмэлт мэдээлэл цуглуулах үүрэгтэй.
- 4.2 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлагнасан аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нэгтгэсэн, зөрүүг олж тогтоосон, ОТАХ-ийн хүсэмжилсэн нөхцөл байдлын болон бусад мэдээллийг агуулсан Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайлангийн төслийг боловсруулна. Санхүүгийн мэдээлэл нь ОТАХ-тэй тохиролцсон төслийн түвшинд хүртэл нарийвчлан задарсан байна. Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайлангийн төсөлд:
  - a) компаниудын төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхэд ашигласан аргачлалын талаар тусгаж, олон улсын мэргэжлийн стандартыг ашигласан гэдгээ харуулна.
  - b) орлогын урсгал бүрийг холбогдох материаллаг байдал болон босготой тодорхойлсон тодорхойлолтын хамт тусгана (шаардлага 4.1).
  - c) Хараат бус хянагч-нэгтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хураангуй, хийсэн үнэлгээний хязгаарлагдмал байдал гэх мэт Хараат бус хянагч-нэгтгэгчийн бэлтгэсэн өгөгдлийн сангийн бүрэн бүтэн, найдвартай байдлын талаар хийсэн үнэлгээг тусгана.
  - d) Шаардлага 4.1(d)-ийн дагуу засгийн газраас тайлагнасан нийт орлогод үндэслэн нэгтгэлийн ажлын хамаарлын хүрээг тусгана.
  - e) ОУИТБС-ын тайлагналын процессын хамрах хүрээнд хамаарагдаж буй бүхий л компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүсэмжилсэн мэдээллийг өгсөн эсэхийг үнэлсэн үнэлгээг тусгана. Хараат бус хянагч-нэгтгэгчид тайлагнахад гарч буй аливаа дутагдалтай тал эсвэл зөрүүг ОУИТБС-ын тайланд тусгана. Үүнд батлагдсан процедурыг зөрчсөн аж ахуйн нэгжийн нэрийг дурдах, мөн энэ нь тайлангийн бүрэн бүтэн байдалд ноцтой нөлөө үзүүлсэн эсэх зэрэг орно.
  - f) Хамрагдаж буй компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь ОУИТБС-ын тайлангийн жилд хамрагдаж буй санхүүгийн тайлант жилийн санхүүгийн тайлангуудаа аудиторoor баталгаажуулсан эсэхийг тусгана. Аливаа зөрүү эсвэл дутагдлыг дурдсан байна. Хэрэв аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан нь нийтэд ил болсон бол ОУИТБС-ын тайланд уншигчдыг энэхүү мэдээллийг хэрхэн авч болох талаар зааварчилсан байх нь зүйтэй.
  - g) Шаардлага 2,3,5,6 болон ОТАХ-ээс хүссэн бусад мэдээллийг багтаасан салбарын суурь мэдээллийг багтаасан байна. Суурь мэдээлэл нь ОТАХ болон Хараат бус хянагч-нэгтгэгчийн зөвшилцсөний дагуу эх сурвалжийг тодорхой заасан байна.
- 4.3 Хэрэв өмнөх ОУИТБС-ын тайланд засаж залруулах арга хэмжээ, шинэчлэлийг зөвлөсөн байвал Хараат бус хянагч-нэгтгэгч нь тэдгээр арга хэмжээний хэрэгжилтийн ахицын талаар дурдана. Хараат бус хянагч-нэгтгэгч нь аудитын практик болон түүнийг олон улсын стандартуудтай ойртуулахад шаардлагатай шинэчлэлүүдийн талаарх зөвлөмж гэх мэт

тайлагналын процессыг сайжруулах чиглэлээр зөвлөмжүүд өгөх нь зүйтэй. Хэрэв тохиромжтой бол олборлох салбарт хийгдэж буй бусад шинэчлэл ОУИТБС-ын хэрэгжилтээс байгалийн баялгийн засаглалд үзүүлж буй үр нөлөөний талаар зөвлөмж өгөх нь зүйтэй.

- 4.4 Хараат бус хянагч-нэгтгэгч нь Хараат бус хянагч-нэгтгэгчийн үйлчилгээний загвар ажлын удирдамжийг ОУИТБС-ын стандарттай нийцүүлэн сайжруулах чиглэлээр ОУИТБС-ын Удирдах зөвлөлд зөвлөмжүүд хүргүүлэх нь зүйтэй.

#### **Үе шат 5 – Хараат бус хянагч-нэгтгэгчийн эцсийн тайлан**

**Зорилго:** Энэ үе шатанд төсөл тайланд ОТАХ-ээс өгсөн бүх зөвлөмжийг тусгаж, эцсийн тайлан боловсруулна.

- 5.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь эцсийн тайланг зөвхөн ОТАХ-ийн зааварчилгааг авсны дараа нийтэд ил болгоно/хэвлэнэ. Тайланг хэвлэлтэд гарахаас өмнө ОТАХ батална. Хэрэв Хараат бус хянагч-нэгтгэгчээс бусад оролцогч тал тайланд санал, байр сууриа ОУИТБС-ын тайланд оруулахыг хүсвэл бичиж буй эх сурвалжийг тодорхой бичсэн байна.
- 5.2 Эцсийн тайланг Монгол Улсын төрийн албан ёсны хэлээр боловсруулж англи орчуулгын хамт хүлээлгэн өгөх бөгөөд орчуулгын хооронд зөрүү гарсан тохиолдолд монгол эхийг баримтална.
- 5.3 Хараат бус хянагч-нэгтгэгч нь эцсийн тайлантай хамт хэвлэж болох цахим материалуудыг<sup>12</sup> (файл) бэлтгэнэ.
- 5.4 ОТАХ-ээр батлуулсны дараа, Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлангийн хураангуй материалыг Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт түүнээс батлан гаргасан стандарт тайлангийн загварыг ашиглан хүргүүлнэ<sup>13</sup>.
- 5.5 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлан аль болох ойлгомжтой байх талаас нь холбогдох арга хэмжээг авна. Тайланг мэргэжлийн хянан тохиолдуулагчаар хянуулж монгол хэл дээрх эхийн хэл найруулгад онцгой анхаарал хандуулна. Мэргэжлийн график дизайны байгууллагаар эх бэлтгүүлсэн байна. Мөн иргэдэд зориулсан хялбаршуулсан тайланг бэлтгэн гаргах бөгөөд тайлангийн мэдээллийг инфографик, харьцуулсан дүрслэл гэх мэт энгийн ойлгомжтой хэлбэрээр боловсруулан хүлээлгэн өгнө.
- 5.6 ОТАХ нь Хараат бус хянагч-нэгтгэгчээс нэгтгэлийн явцад цуглуулсан бүх мэдээллийг тухайлбал холбоо барих хаяг зэрэг ажлын албанд хүлээлгэж өгөхийг шаардаж болно.
- 5.7 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлангийн эх файл (word document), холбогдох хавсралт хүснэгтүүд (excel document)-ийг ажлын албанд хүлээлгэн өгнө.
- 5.8 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлангийн тоон мэдээлэлд хийсэн бүх тохируулгыг Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулна.

## **4 ТАН ЭВСЭЛ ЗЭРЭГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **1. Ерөнхий шаардлага**

---

<sup>12</sup> CRV эсхүл Эксел форматтай байх ба тайлан дахь хүснэгт, графикуудыг багтаасан байна.

<sup>13</sup> Хураангуй тайлангийн батлагдсан сүүлийн маягыг эндээс татаж авах. <https://eiti.org/document/eiti-summary-data-template>

- ОУИТБС-ын 2019 оны ажлын даалгаварт Баталгаажуулалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх, урьд жилүүдийн нэгтгэл тайлангуудаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийн өөрчлөлтийг авч үзэх, шинэ стандартын шаардлагыг бүрэн үзэх.
- Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэх буцаан олгож буй мэдээллийг компани тус бүрээр, орхигдсон газар нөхөн сэргээлт хийж буй байгаль орчны нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл бүхий компаниудын жагсаалт, уул уурхайн эдэлбэрт өртсөнөөр нөхөн сэргээгдээгүй орхигдсон газрын мэдээллийг аймаг тус бүрээр гаргаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг тайланд оруулах.
- Уул уурхайн төсөл бүрээр тайлагнах шаардлагыг хангахад анхаарах, ингэхдээ тухайн улс орны хууль эрх зүйн орчин, татварын тогтолцооноос хамааран төслөөр тайлагнах шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй бол тайланд хамрагдаж байгаа орлогын урсгалуудаас төслөөр ялган тайлагнах боломжтой төлбөрүүдийг эхний ээлжид төсөл тус бүрээр задлан тайланд тусгахыг ОУИТБС-аас зөвлөж байна. Тиймээс тусгай зөвшөөрлийн төлбөр, АМНАТ, газар, ус ашигласны төлбөр, байгаль орчны барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт гэх мэт төлбөрүүдийг төслөөр ялган тайлагнахад анхаарч, тайланд оруулах.

## **2. Эдийн засагт оруулж буй хувь нэмэр**

- Олборлох салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг байгалийн нөөцийн төрөл тус бүрээр үзүүлэхдээ дараах байдлаар ангилан авч үзэж тайланд тусгах:
  - Ашигт малтмал: (зэс, алт, мөнгө, төмрийн хүдэр, нүүрс, газрын тос, түгээмэл тархацтай ашигт малтмал)
  - Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордууд
- Бичил уурхайн үйл ажиллагаанаас эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тайланд тусгах. Хэдийгээр бичил уурхайн салбар, тэр дундаа олборлон борлуулсан бүтээгдэхүүн, ажиллах хүч, төлсөн татвар хураамжийн мэдээлэл нь төдийлөн найдвартай бус (мэдээлэл нь баталгаатай бус) байж болох ч наад зах нь төрийн холбогдох байгууллагуудад байгаа бичил уурхайн тоо баримт, мэдээллийг тайланд тусгах нь зүйтэй. Түүнчлэн мэдээлэл найдвартай бус байж болох шалтгаан, үндэслэл, түүнийг арилгахтай холбоотой дүгнэлт зөвлөмжийг тайланд тусгах.
- Эрдэс баялгийн салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг үнэлэхэд зөвхөн олборлосон борлуулсан бүтээгдэхүүн, экспорт, төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээнд үндэслэх нь учир дутагдалтай юм. Иймээс эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж байгаа, оператор, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгч компаниудын эрдэс баялгийн салбар дахь ажлын байр, ажиллах хүчний тоо хэмжээ зэрэг эдийн засгийн бусад дагалдах (шууд бус үр нөлөө) зэрэг, сөрөг нөлөөллийг судалж үнэлэх.
- Эрдэс баялгийн салбарт импортоор орж байгаа бараа бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж, гадаадын ажиллах хүчний мэдээллийг бусад салбараас ялган авч тайланд тусгах

## **3. Тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдал, мэдээллийн чанар, үнэн зөв байдал**

Тусгай зөвшөөрлийн талаар мэдээллийг дараах байдлаар ангилан авч үзэж тайланд тусгах:

- Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох болон тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг тогтоон нийтэд зарлахтай холбоотой бодлого, дүрэм журам нийтэд ил тод байгаа эсэхийг тайланд тусгах
- Тусгай зөвшөөрлийн өргөдлийн тоо, огноо, талбайн солбицол, өргөдлийг шийдвэрлэсэн үйл явц, ялангуяа орон нутгийн захиргаанаас санал авах мэдэгдлийн огноо, ирсэн хариу, түүний огноог тайланд тусгах. Цаашид эдгээр мэдээллийг ил тод болгох талаар тодорхой зөвлөмж өгөх.

- Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох зориулалтаар талбай зарласан шийдвэр, түүний огноо, тогтоосон талбай, сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, эцсийн шийдвэрийн мэдээллийг тайланд тусгах.
- Сонгон шалгаруулалтын хорооны бүрэлдэхүүн, тэдгээрт тавигдах шаардлагыг, тайланд тусгах.
- Олгосон тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийн нэгдсэн хүснэгтийг ил тод болгох. Ингэхдээ нээлттэй мэдээллийн стандартын дагуу боловсруулалт хийж ашиглах, харьцуулан судлах бололцоотой болгох, ОУИТБС-ын нэгтгэл тайлан дээрх мэдээллийн линкийг зааж өгөх.
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдалд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ил тод байдалтай ижил түвшний шаардлага тавих
- Хууль тогтоомж зөрчиж олгогдсон тусгай зөвшөөрөл байгаа эсэхийг түүврийн аргаар дүн шинжилгээ хийж тайланд тусгах. (Зарим нэг зөрчлийн тухай мэдээ, баримтыг ТАН эвслээс өгөх боломжтой).
- Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш тусгай зөвшөөрөл олгосон үйл явцад иргэдийн оролцоо буюу уг хуульд заасан Сонсох ажиллагааны журмыг хэрхэн хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, түүний хэрэгжилтийг хангах талаар тодорхой дүгнэлт зөвлөмж өгөх.

#### **4. Эрдэс баялгийн салбар дахь төрийн оролцоо**

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ил тод байдлын тайланг бие даасан бүлэг болгож оруулах. Үүнд:

- Эрдэнэс МГЛ ХК түүний хараат болон охин компаниудын мэдээлэл, түүнчлэн Эрдэнэт үйлдвэр, Шивээ-Овоо, Багануур, Мон-Атом ХК-ийн эзэмшлийн бүтцэд 2019 онд гарсан өөрчлөлтүүдийг зураглалаар үзүүлж, тэдгээртэй холбоотой шийдвэрүүдийг ил тод болгох.
- Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг, тэдгээрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийн мэдээллийг ил тод тайланд тусгах.
- Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдийн нэр, ажил албан тушаал, ажлын хаяг зэрэг мэдээллийг Эрдэнэс МГЛ ХК болон бусад компани гэсэн ангиллаар гаргаж, тайланд тусгах.
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн Хараат бус гишүүдийг томилох үйл явц, тавих шаардлага, түүнтэй холбоотой дүрэм журмыг ил тод болгож, ил тод байдлыг хангах чиглэлээр дүн шинжилгээ хийж, холбогдох зөвлөмжийг өгөх.
- Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын жилийн төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ил тод болгох.
- Төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтын нөхцөл, компани болон төр хоорондын шилжүүлэг, тэдгээртэй холбоотой гэрээ хэлцэл, шийдвэрийг ил тод болгох
- Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын цэвэр ашиг, түүнээс ноогдол ашиг тооцох, хуваарилах аргачлал, дүрэм журам, түүний хэрэгжилтийг тайланд тусгах. Тухайлбал, Эрдэнэс Тавантолгой ХК ногдол ашиг хуваарилбал улсын төсөв орох уу, эсхүл Эрдэнэс МГЛ ХК-д орох уу, Эрдэнэс МГЛ ХК-ийн хуваарилсан ногдол ашгийн хэдэн хувь нь төсөвт ордог, түүнийг хэрхэн тооцдог гэх мэт асуудлуудыг тодруулж тайланд тусгах;

#### **5. Мэдээллийн баталгаажуулалт**

- Үндэсний аудитын газар төрийн болон орон нутгийн өмчит компанид хийсэн хяналт шалгалт, тэдгээрийн дүгнэлтийг ил тод болгох. Энэ талаарх зөвлөмжийг тайланд тусгах.

#### **6. Ашигт хүртэгч эздийн мэдээллийн ил тод байдал**

- Ашиг хүртэгч эздийн мэдээллийн ил тод байдлыг хангах;

#### **7. Гэрээний ил тод байдал**

- Байгаль орчны нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрлийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас авсан аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн байршил, үйл ажиллагаа явуулж буй аймаг, сум, эздийн мэдээлэл, орон нутагтай байгуулсан Нөхөн сэргээлтийн гэрээнүүдийн мэдээллийг тайланд тусгах. Эдгээр гэрээ нь Нийгмийн хариуцлагын гэрээ, байгаль орчныг нөхөн сэргээх гэрээ, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх гэрээ гэх мэтээр орон нутагт янз бүрээр нэрлэгдсэн байж болохыг анхаарах.
- Тайлангийн нэгтгэл тайланд гэрээний нээлттэй байдлыг авч үзэхдээ АМТ-ын 42-р зүйл, ЗГ-ын 2016 оны 179-р тогтоолын хүрээнд байгуулагдсан гэрээний хэрэгжилт түүний ил тод байдлыг авч үзэх. Ингэхдээ гэрээний хороо байгуулсан эсэх, Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан эсэхийг тодруулж, оруулах
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг 2015 онд Засгийн газраас шинэчлэн батлахдаа нууцлалын заалтыг хассан. Батлагдсан шинэ загварын дагуу хийгдсэн бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ил тод болгох асуудал дээр хойрго хандаж байгаа талаар тайланд тусгах, тодорхой зөвлөмж өгөх;  
Газрын тосны эрлийн гэрээний мэдээлэл, эрх зүйн үндэслэл, гэрээний талууд, гэрээний зорилго, хугацаа, үндсэн нөхцлийн мэдээллийг тайланд тусгаж, гэрээний ил тод байдлыг хангах зөвлөмж өгөх.

#### **8. Дэд бүтэц, бартерын гэрээ**

- Уул уурхайн салбарт хийгдэж буй Концессын болон бартерийн солилцооны гэрээнүүдийг нээлттэй болгох. Ингэхдээ мөнгөн дүнгийн хэмжээгээр ОТАХ-тэй ярилцаж босго тогтоох шийдвэр гаргуулах.

#### **9. ОУИТБС-ын тайлангийн маягтыг сайжруулах чиглэлээр**

- Төсвийн хөрөнгө оруулалттай адил төстэй төлбөр байгаа эсэх, байгаа бол тайлагнах материаллаг босгыг тогтоон ил тод болгох
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг компани тус бүрээр гаргах, ингэхдээ аль аймагт ажилладаг компани хэдийг төвлөрүүлснийг харах боломжтойгоор боловсруулж, тайланд харуулах. Үүнд үндэслэн 2016 оны 01 сарын 01-ээс хэрэгжиж эхлэх Төсвийн тухай хуулийн 60-р зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж өгөх.

## **5 Хараат бус хянагч-нэгтгэгчид тавих мэргэжлийн шаардлага**

Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниудын төлсөн төлбөр, засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхдээ заавал олон улсын мэргэжлийн стандартуудыг ашиглана (шаардлага 4.9). Тендерт оролцогсад нэгтгэх/тайлан гаргахад ашиглах процедуртаа зохих мэргэжлийн стандартуудыг заавал баримтлан ажиллана (мөн түүнийг хэрхэн баримтлахаа харуулна).

Хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах чадвараа нотлон харуулна:

Хараат бус хянагч нэгтгэгч нь аудитын компани, эсхүл түншлэл (консорциум) байх ба дараах шаардлагыг хангасан байна:

- Аудитын компани, эсхүл түншлэлийн аудиторууд нь ямар чиг үүрэгтэй, ямар оролцоотой байхыг тусгаж, Монгол Улсад зохион байгуулагдах уулзалт, сургалт, ОУИТБС-ын Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөлийн хуралд заавал биечлэн оролцох үүрэг хүлээсэн байх.
- Аудитын компани, эсхүл түншлэлийн аудиторууд нь Монгол улсын олборлох салбар, төсвийн орлого, татвар, төлбөр, гаальтай холбоотой хууль эрх зүйн орчны өндөр мэдлэгтэй, тайлан гаргах, дүгнэлт гаргуулах, аудит хийлгэх асуудлаар Засгийн газар, агентлаг, эрх бүхий байгууллагаас гарган мөрдүүлж байгаа журам, заавар, маягт, тайлан, бусад мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна.
- Нягтлан бодохын мэргэжлээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдагчтай (олон нийтийн эрх бүхий нягтлан бодогч, мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл мэргэшсэн нягтлан бодогчтой адил түвшиний ур чадвартай) болох нь нотлогдсон байх;
- Олон улсын Нягтлан бодогчдын холбоонд харьяалагдах нягтлан бодохын байгууллагын мэргэшсэн гишүүн нягтлан бодогчтой байж болно. Компани нь шаардлага хангасан ажилтнуудтай байх хийгээд үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чадавхтай байна;
- ОУИТБС-ын мэдлэгтэй, энэ чиглэлээр өмнө нь тайлангийн нэгтгэл болон баталгаажуулалт хийж байсан туршлагатай байх нь давуу тал ч, заавал шаардахгүй;
- Аудитын компани, эсхүл түншлэлд оролцох компанийн нэг нь аудит хийх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын Сангийн яамнаас авсан, тэр нь хүчинтэй байх ёстой. Оролцох сонирхлоо илэрхийлэхдээ тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсралтаар заавал ирүүлнэ;
- Хэрэв түншлэлийн хэлбэрээр оролцох бол түншлэл байгуулсан тухай нотлох баримтыг сонирхлоо илэрхийлэхдээ хуулбарыг нь заавал ирүүлнэ. Хэрэв өөрийн салбар, эсхүл охин компанитай хамтран гүйцэтгэх бол хамтран хэрэгжүүлэх тухай нотолгоог заавал ирүүлнэ;
- Энэхүү ажлыг чанартай, хараат бус байдлаар явуулах үүднээс Хараат бус хянагч-нэгтгэгч нь тендерийн саналдаа бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчил, түүнээс яаж зайлсхийх боломжтой талаарх мэдээллийн хамт тусгах шаардлагатай. Үүнд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг геологи, газрын тос, уул уурхай, хүнд үйлдвэрийн компаниудын санхүүгийн нэгдсэн тайланд сүүлийн 3 жил аудит хийсэн бол ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзэх бөгөөд хэрэв сонгогдож энэ ажлыг хийхээр болбол хэрхэн хараат бус ажиллах талаар холбогдох тайлбар, танилцуулгыг заавал ирүүлнэ.

## 6 Бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацаа

Энэ даалгаврын дагуу хийгдэх ажил нь 2020 оны 05 дугаар сарын 22-ний өдөр эхэлж, Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны тайланг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор батлан гаргасан байна.

Гэрээнд гарын үсэг зурах	2020.05.22
Цар хүрээ тодорхойлох үе	2020.06.05
⇒ Цар хүрээний тайлан	2020.06.19
Урьдчилсан дүн шинжилгээ	2020.07.06
⇒ Эхлэлийн тайлан	2020.07.27
Мэдээлэл цуглуулах	2020.08.10
Анхан шатны нэгтгэл	2020.09.14

Зөрүүг судлан тогтоох	2020.09.18
⇒ Тайлангийн төсөл	2020.11.02
Эцсийн тайлан боловсруулах	2020.12.01
⇒ Эцсийн тайлан	2020.12.15

Төлбөрийг дараах байдлаар хэсэгчлэн хийнэ:

- 10%> -ийг гэрээнд гарын үсэг зурсны дараа
- 30%> -ийг эхлэлийн тайлан хүлээлгэн өгсний дараа
- 50%> -ийг тайлангийн төсөл хүлээлгэн өгсний дараа
- 10%> -ийг ОУИТБС-ын тайланг ОТАХ-ээс баталж, нийтэлсний дараа

## 7 Сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах

Хараат бус хянагч- нэгтгэгчийг Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 39 дүгээр заалтын дагуу Зөвлөх сонгох чанарын үнэлгээний аргаар сонгон шалгаруулна.

Гэрээ байгуулах эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Уул Уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба байна.

## 8 Хавсралт – Дагалдах баримт бичиг

Холбогдох хууль тогтоомж гэх мэт олборлох салбарын засаглалын тогтолцоо ба татварын бодлогын талаарх баримт бичгүүд:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга [www.eiti.org](http://www.eiti.org)
- Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга - <http://www.eitimongolia.mn/>
- ОУИТБС Стандарт 2019 - <http://www.eitimongolia.mn/mn/eiti-standard>

ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө ба бусад баримт бичгүүд

- ОУИТБС-ын 2020 оны төлөвлөгөө - <http://www.eitimongolia.mn/mn/work-plan>

Өмнөх ОУИТБС-ын тайлангууд

- ОУИТБС-ын тайлангууд - <http://www.eitimongolia.mn/mn/reconciliation-report>
- Түүхэн тоо мэдээ - <http://e-reporting.eitimongolia.mn/>

Бусад холбогдох баримт бичгүүд (жилийн үйл ажиллагааны тайлан г.м)

- Хуулиуд - <http://www.eitimongolia.mn/mn/mongolian-laws>
- Засгийн газрын тогтоолууд - <http://www.eitimongolia.mn/mn/resolution-of-government>

- Ерөнхий сайдын захирамж - <http://www.eitimongolia.mn/mn/orders>
- Журам, заавар - <http://www.eitimongolia.mn/mn/regulations>